



УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018.04.17 № 61/2089

танай _____-ны № _____-т

Гүйцэтгэгч сонгох ажиллагааг
түр түдгэлзүүлэх тухай

Танай яамнаас зарласан "Геологийн цахим мэдээллийн сан /улсын хэмжээнд/-гийн гүйцэтгэгч сонгон шалгаруулах" УУХҮЯ/201801004 дугаар бүхий тендер шалгаруулалтын 3 дугаар багцад оролцсон "Ай ти зон" ХХК-иас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасны дагуу гомдол гаргаад байна.

Иймд дээрх хуулийн 55 дугаар зүйлийн 55.4-т заасны дагуу гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр хугацаагаар түдгэлзүүлж байна. Гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгүүдийг 2018 оны 04 дүгээр сарын 20-ны дотор ирүүлнэ үү. Үүнд:

1. Гэрээ байгуулах эрх олгох тухай захиалагчийн шийдвэр;
2. Тендерийн урилга /сонинд зарласан хуулбар/;
3. Тендерийн баримт бичиг;
4. Тендерт оролцогчдын ирүүлсэн тендер;
5. Тендерийн нээлтийн тэмдэглэл;
6. Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, шийдвэр;
7. Тендерт оролцогчид болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг;
8. Үнэлгээний хорооны гишүүдийн АЗ гэрчилгээ, холбогдох бусад баримт бичиг;
9. Гэрээ байгуулах эрх олгох болон шалгараагүй талаар мэдэгдлийг оролцогч нарт хүргүүлсэн талаар нотлох баримт;

Гомдлыг хянах явцад тендерийн хүчинтэй байх хугацаа дуусах тохиолдолд хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасны дагуу төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гарган, уг хугацааг сунгуулах арга хэмжээ авч ажиллана уу.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН
ГАЗРЫН ДАРГА



П.БИЛГҮҮН

Since 1997

itzone

Accelerate Your Success

АЙ ТИ ЗОН ХХК

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8-р хороо, Бага тойруу 14200, Сүхбаатарын талбай,

Сити Тауэр, 4 давхар

Утас: (+976) 77317731

Үйлчилгээний лавлах: (+976) 77312424

И-мэйл: crm@itzone.mn, www.itzone.mn

Дугаар 01/753

Огноо 2018 Сар 04 Өдөр 16

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Г.НАНДИНЖАРГАЛ ТАНАА

Тендерийн үр дүн, захиалагчийн шийдвэрт
гомдол гаргах нь

“Ай Ти Зон” ХХК нь “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам”-наас зарласан Геологийн цахим мэдээллийн сан /улсын хэмжээнд/-гийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах УУХҮЯ/201801004 дугаартай тендерийн Багц-3 “Геологийн цахим мэдээллийн сан /улсын хэмжээнд/-гийн үйлдлийн системийг виртуалчлан удирдах программ” тендерт оролцож саналаа 2018 оны 03-р сарын 14-ний өдөр хүргүүлсэн билээ.

Тус тендерийн мэдэгдлийг 2018 оны 4 сарын 11-ний өдөр хүлээн авсан ба үүнд манай компанийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.7 дах заалт “барааны хувьд эрх бүхий байгууллагаас олгосон чанарын гэрчилгээ, үйлдвэрлэгчийн итгэмжлэл” болон тендерийн баримт бичгийн ТООЗ 18.1 (а) дах хэсэгт заасан “Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл /Албан ёсны дистрибьютер болохыг баталсан гэрчилгээний хуулбаруудыг орчуулгын хамт ирүүлэх/” шаардлагуудыг хангаагүй тул татгалзсан гэсэн тайлбар ирүүлсэн. Үүнийг бид үндэслэлгүй гэж үзэн доорх тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1. DELL компани нь 2016 онд EMC, VMWARE компаниудтай нэгдэн DELLEMC нэрээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд манай компанийн энэхүү тендерт нийлүүлэхээр санал болгосон VMWARE лиценз нь DELL компанийн бүтээгдэхүүн юм. Мөн манай компанийн тендерийн саналд хавсаргасан DELL-н Үйлдвэрлэгчийн зөвшөөрөлд Software гэж тусгасан бараа нь VMWARE лицензийг илэрхийлж буй юм.

Үүнийг нотлох баримт бичгүүдийг бид тендерийн саналд хавсарган өгсөн ба энэхүү албан тоотод мөн хавсаргав. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл лавлагааг DELLEMC компанийн Монгол улс дах төлөөлөгчид болох Т. Сэлэнгэ, Л.Баянзул нараас авна уу.

	Т. Сэлэнгэ	Л.Баянзул
Утас	88881777	99071093
E-mail	Selenge_tumurbaatar@dellteam.com	Bayanzul_lodoysamba@dellteam.com

Иймд дээрх нөхцөлүүдийг харгалзан үзэж тус тендерийн шийдвэр үнэн зөв гарсан эсэхийг нягтлан үзэж үнэлгээг шалгаж өгөхийг хүсье.

Дараах материалуудыг баталгаа болгон хавсаргав.

1. “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам”-наас ирүүлсэн 3/991 тоот албан бичиг,
2. DELLEMC компанийн мэдэгдэл,
3. Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл,
4. DELLEMC компанийн албан ёсны дистрибьютерийн гэрчилгээ

Энэхүү гомдлын хувийг Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлэв.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



У.НАРАНБААТАР



УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018. 04. 30 № 6-1/2425

танай _____-ны № _____-т

Гомдол хянан үзсэн тухай


Танай яамнаас зарласан "Геологийн цахим мэдээллийн сан /улсын хэмжээнд/-гийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах" УУХҮЯ/201801004 дугаар бүхий тендер шалгаруулалтын 1 дүгээр багц болох компьютер, техник тоног төхөөрөмж нийлүүлэх тендерт оролцсон "Саммит компьютер технологи" ХХК, 3 дугаар багцад оролцсон "Ай ти зон" ХХК нараас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид "хууль" гэх/-ийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасны дагуу гаргасан гомдлыг хуулийн 55.2 дахь хэсэгт заасны дагуу ирүүлсэн баримт, материалд үндэслэн хянан үзлээ.

Тендер шалгаруулалтын 1 дүгээр багцын хувьд захиалагчийн "хамгийн сайн" тендер ирүүлсэн гэж үнэлсэн "Бодь электроникс" ХХК-ийн санал болгосон "HPE Proliant DL380 Gen 10 8SFF" загвар бүхий серверийн RAID/Internal storage controllers-ийн үзүүлэлт болон HPE MSA 2050 SAN Dual Controller SFF загвар бүхий storage-ийн co-pilot optimize base primary POS-ийн үзүүлэлт нь тус тус захиалагчийн шаардсан үзүүлэлттэй дүйцэх эсэхийг нягталсны үндсэн дээр тухайн багцын тендер шалгаруулалтын үнэлгээг дахин хийх нь зүйтэй байна.

Тендер шалгаруулалтын 3 дугаар багцад оролцсон "Ай ти зон" ХХК нь DELL EMC компаниас ирүүлсэн үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг баталгаат орчуулгын хамт, албан ёсны дистрибьютерийн гэрчилгээг баталгаат орчуулгын хамт тус тус тендертээ хавсарган ирүүлсэн байхад тендерийн баримт бичгийн Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн ТООЗ 18.1 /а/-д заасныг хангаагүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байх тул тухайн багцын тендер шалгаруулалтын үнэлгээг дахин хийх нь зүйтэй байна.

Хувийг: "Ай ти зон" ХХК, "Саммит компьютер технологи" ХХК нарт.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.НАРАНЦОГТ

УУЛ УУРХАЙ ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ ТАНАА

2018.05.30

Үнэлгээний дүгнэлт хүргүүлэх тухай

Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/07 дугаар тушаалаар байгуулагдсан "Геологийн цахим мэдээллийн сан" /улсын хэмжээнд/-ийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг гурван багцаар зохион байгуулсан.

Үнэлгээний хорооноос 1 дүгээр багц болох компьютер, техник тоног төхөөрөмж нийлүүлэх болон 3 дугаар багц болох үйлдлийн системийг виртуалчлан удирдах программ нийлүүлэх багцуудыг дахин нээлттэй зарлах нь зүйтэй байна.

ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА
БӨГӨӨД АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДЭД ДАРГА *М.ЭНХЖАРГАЛ* М.ЭНХЖАРГАЛ

*Баяраг ТЗУГ-г
Paul
5/4*

*Мартааг тогтоо
гарсан тул
үнэлгээний
Баяраг
хөрсөг оорчин
зохион байгуулах!*